

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/139/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь Сайншанд сум
2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Энхцэцэг

Утас: 70523020

Аудитор:

Б.Отгон-Өлзий

Утас: 99844655

Цахим хаяг: shilenbalanceaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11.	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.12.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.13.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.14.	Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
	Менежментийн захидал	11
3.1	Зардлын данстай холбоотой:.....	11

1 Аудитын гэрчилгээ


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сафр: dornogovi@audit.gov.mn

АЙМГИЙН БОЛОВСРОЛ
СОЁЛЫН ГАЗРЫН ДАРГА
Ч.ОТГОНБАЯР ТАНАА

2020.02.28 № 1-6/137
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Боловсрол соёлын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Боловсрол соёлын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Боловсрол соёлын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Ч.Отгонбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Дорноговь аймгийн Боловсрол, соёлын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01-р сарын 25-ны өдрөөс 01-р сарын 28-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Шилэн баланс аудит ХХК-ний аудитор Б.Отгон-Өлзий хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01-р сарын 23-ны өдрийн 34 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Боловсрол, соёл урлагийн газар нь сургалтын чанарт ахиц гаргах, мэргэжил, арга зүйн хөгжлийг дэмжсэн таатай орчин бүрдүүлэх, хичээл сурлагын өдөр тутмын үйл ажиллагааг чанартай бэлтгэн зохион байгуулах, СӨБ-ын үйлчилгээний шинэ арга хэлбэрийг дэмжих замаар хүүхэд бүрийг зохион байгуулалттай сургалт, хөгжүүлэх үйл ажиллагаанд тогтмол хамруулж, бага насны хүүхдийг хөгжүүлэх ажлын чанарыг сайжруулах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Боловсрол, соёлын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Боловсрол, соёл урлаг, спортын үйлчилгээний чанар, хүртээмж, сургалтын орчныг сайжруулах
- Багш хөгжлийг дэмжих, чадварлаг боловсон хүчнээр хангах
- Хүний хөгжлийг дэмжих

Байгууллагын төсвийн захирагч нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Боловсрол, соёлын газар нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд 42 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож эрсдлийн түвшинг бага гэж үнэлэн 2 хувиар сонгов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,500,693.9 мянган төгрөгөөс тооцон 30,013.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40,199.7 мянган төгрөгөөр буюу 66,5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	7,852.3	11,078.1	4,225.8
Урьдчилгаа			
Бараа материал	2,049.5	2,433.4	383.9
Үндсэн хөрөнгө	60,414.9	100,614.6	40,199.7
Нийт хөрөнгө	70,316.7	114,126.1	43,809.4
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	70,316.7	114,126.1	43,809.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	70,316.7	114,126.1	43,809.4

Авлага дансны үлдэгдэл жилийн эцэст 4,225.8 мянган төгрөгөөр өссөн байна. Авлагын үлдэгдэл нь Дэлхийн банкнаас хэрэгжиж байгаа боловсролын шинэчлэл хөтөлбөрийн зарцуулагдаагүй үлдэгдлийг авлагаар бүртгэн тайлагнаж, тайлант онд улсын төсвөөс буцаан авч зарцуулснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь аж ахуйн материал 409.1 мянган төгрөгөөр, түлш, шатах тослох материалын үлдэгдэл 19.1 мянган төгрөгөөр тус тус өссөнөөс шалтгаалжээ. Бүх нэр төрлийн бараа материал бүрэн ашиглагдах буюу ашиглагдаж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь хандив тусламжаар мэдээллийн кабинетыг тохижуулан 57,631.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 4,870.0 мянган төгрөгийн тавилга хэрэгслийг үнэ төлбөргүй өгсөнтэй холбоотой байна. Мөн төсвийн хөрөнгөөр 5,318.6 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл худалдан авсан байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Боловсрол, соёл урлагийн газарт орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 1,562,009.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,562,009.8 мянган төгрөгийг урсгал зардалд, зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,562,009.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Урсгал зардлыг нийт дүнгээр нь 61,315.9 мянган төгрөгөөр хэмнэсэн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 2,791.3 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 6,868.5 мянган төгрөгөөр, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг 37,786.4 мянган төгрөгөөр, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 13,869.6 мянган төгрөгөөр, гэрэл цахилгааны зардлыг 145.5 мянган төгрөгөөр, цэвэр бохир усны зардлыг 242.2 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 732.6 мянган төгрөгөөр, тээвэр шатахууны зардлыг 198.7 мянган төгрөгөөр, шуудан холбооны зардлыг 478.2 мянган төгрөгөөр, ном хэвлэлийн зардал 272.3 мянган төгрөгөөр, хог хаягдал зайлуулах зардлыг 204.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас 189,476.1 мянган төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс 43,697.8 мянган төгрөгийн нийт 233,173.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс худалдан авахад 1,547.0 мянган төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 225,079.8 мянган төгрөгийг, бусад зардалд 2,400.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 5 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 859.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 719.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч, 139.1 мянган төгрөгийг төлүүлэхээр 2 акт тогтоолоо.

Аудитаар дараах 859.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 139.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Албан томилолтын зардлаас нэр бүхий 3 ажилтанд 48.000 /Дөчин найман мянга/ төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан нь Үнэн зөв байх, Эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байх ба НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Тээвэр шатахууны зардлаас жолоочийн тооцооны хуудасгүй 91,100.00 /ерэн нэгэн мянга нэг зуу/ төгрөгийг зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Аудитаар илэрсэн 719.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Боловсрол, соёл урлагийн газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 142 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгснөөс бүрэн хэрэгжүүлж, 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой:

3.1.1 Илрүүлэлт:

Тээвэр шатахууны зардлаас жолоочийн тооцооны хуудасгүй зарцуулсан байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7” Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 13.6 “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Тээвэр шатахууны зардлыг зориулалт бусаар зарцуулсан байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид НББ-ийн тухай хуулийг хэрэгжүүлэн анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Балансын данстай холбоотой асуудал:

3.2.1 Илрүүлэлт:

Бараа материалын ангиллыг буруу бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар”-ын 4.16 “Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг мөрдөнө” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй.

3.2.2 Эрсдэл

Бараа материалын үлдэгдэл тайланд алдаатай, үнэн зөв тусгагдахгүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж

Цаашид алдаа дутагдлыг дахин давтан гаргахгүй байх, бараа материалыг дансны ангиллын дагуу бүртгэх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>9,901,790.00</u>	<u>13,511,474.00</u>
33	АВЛАГА	7,852,250.00	11,078,100.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,776,000.00	00.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	10,078,100.00
335	Бусад авлага	6,076,250.00	1,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	6,076,250.00	1,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,049,540.00	2,433,374.00
354	Хангамжийн материал	2,049,540.00	2,433,374.00
35410	Бичиг хэргийн материал	152,740.00	108,300.00
35420	Аж ахуйн материал	1,896,800.00	2,305,974.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	19,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>60,414,915.34</u>	<u>100,726,602.10</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	60,414,915.34	100,726,602.10
392	Биет хөрөнгө	51,454,915.34	91,766,602.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,392,480.00	10,392,480.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-5,196,240.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	26,000,000.00	26,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-26,000,000.00	-26,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	119,102,603.55	182,052,778.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	-88,916,333.77	-109,194,484.47
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,132,982.00	24,002,982.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,358,297.34	-14,287,418.24
39214	Бусад үндсэн хөрөнгө	792,720.00	792,720.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-132,626.64
39217	Ном	3,308,760.90	3,336,410.90
393	Биет бус хөрөнгө	8,960,000.00	8,960,000.00
39301	Програм хангамж	1,674,500.00	1,674,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,674,500.00	-1,674,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,960,000.00	8,960,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>70,316,705.34</u>	<u>114,238,076.10</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>70,316,705.34</u>	<u>114,238,076.10</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	70,316,705.34	114,238,076.10
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	193,915,094.90	193,915,094.90
51101	Өмч: - төрийн	193,915,094.90	193,915,094.90
512	Хуримтлагдсан үр дүн	-90,890,305.47	-46,968,934.71
51210	Өмнөх үеийн үр дүн	-90,890,305.47	-92,666,305.47
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	45,697,370.76
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-32,708,084.09	-32,708,084.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>70,316,705.34</u>	<u>114,238,076.10</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	618,697,357.55	1,857,685,264.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,848,000.00	62,501,553.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,848,000.00	62,501,553.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,848,000.00	62,501,553.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,848,000.00	62,501,553.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	616,765,357.55	1,795,183,711.11
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	266,441,300.00	1,562,009,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	251,441,300.00	1,562,009,800.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	15,000,000.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	84,000.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	350,264,705.55	233,173,911.11
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	17,943,452.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	43,697,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	332,321,253.55	189,476,111.11
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	59,352.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	59,352.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	549,610,741.89	1,811,987,893.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	549,610,741.89	1,811,987,893.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	549,545,118.89	533,360,382.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	175,279,373.56	214,972,066.00
210101	Үндсэн цалин	117,143,190.00	163,123,835.00
210102	Нэмэгдэл	44,176,863.56	31,835,091.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,645,200.00	10,704,600.00
210104	Урамшуулал	6,314,120.00	9,308,540.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,319,629.44	26,357,459.00
210201	Тэтгэврийн даатгал	18,034,073.44	18,141,427.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,486,324.00	2,142,287.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,300,698.00	1,713,829.00
210204	Ажилгүйдлийн даатгал	317,058.00	387,555.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,181,476.00	3,972,361.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,676,028.00	14,487,526.00
210301	Гэрэл, цахилгаан	1,351,010.00	1,456,360.00
210302	Түлш, халаалт	8,974,410.00	12,035,688.00
210303	Цэвэр, бохир ус	2,350,608.00	995,478.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,654,472.00	9,423,282.00
210401	Бичиг хэрэг	2,767,560.00	1,341,440.00
210402	Тээвэр, шатахуун	2,868,445.00	7,020,675.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,414,767.00	364,667.00
210404	Ном, хэвлэл	16,000,000.00	00.00

Дорноговь аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,000.00	295,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	459,700.00	400,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	4,388,800.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	4,388,800.00
2107	Томилолт, зочны зардал	5,744,000.00	4,000,000.00
210702	Дотоод албан томилолт	5,744,000.00	4,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	232,030,886.77	214,117,895.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	232,030,886.77	214,117,895.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,840,729.12	45,613,354.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,207,118.22	2,900,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	38,350,177.00	15,177,216.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,283,433.90	27,536,138.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,623.00	1,278,627,511.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	1,213,164,521.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	552,689,309.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	659,475,212.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	65,623.00	65,462,990.11
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	65,623.00	65,462,990.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	69,086,615.66	45,697,370.76
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	69,086,615.66	45,697,370.76

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>542,932,025.77</u>	<u>1,795,183,711.11</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	542,932,025.77	1,795,183,711.11
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	239,225,300.00	1,562,009,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	239,225,300.00	1,562,009,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	303,706,725.77	233,173,911.11
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	17,943,452.00	00.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	62,544,148.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	43,697,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	223,219,125.77	189,476,111.11
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>541,388,605.77</u>	<u>1,789,837,439.11</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	541,388,605.77	1,789,837,439.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	541,222,982.77	511,209,928.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	176,271,701.00	215,904,066.00
210101	Үндсэн цалин	129,998,151.00	164,055,835.00
210102	Нэмэгдэл	32,314,230.00	31,835,091.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,645,200.00	10,704,600.00
210104	Урамшуулал	6,314,120.00	9,308,540.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,244,076.00	26,425,459.00
210201	Тэтгэврийн даатгал	16,958,520.00	18,209,427.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,486,324.00	2,142,287.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,300,698.00	1,713,829.00
210204	Ажилгүйдлийн даатгал	317,058.00	387,555.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,181,476.00	3,972,361.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,718,800.00	14,518,800.00
210301	Гэрэл, цахилгаан	1,393,782.00	1,487,634.00
210302	Түлш, халаалт	8,974,410.00	12,035,688.00
210303	Цэвэр, бохир ус	2,350,608.00	995,478.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,511,969.00	6,426,628.00
210401	Бичиг хэрэг	749,829.00	717,360.00
210402	Тээвэр, шатахуун	2,786,445.00	2,801,261.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,414,767.00	361,807.00
210404	Ном, хэвлэл	16,000,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон	144,000.00	295,800.00

Дорноговь аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	416,928.00	2,250,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	4,400,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	4,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,520,000.00	4,000,000.00
210702	Дотоод албан томилолт	7,520,000.00	4,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	239,243,836.77	223,634,975.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	239,243,836.77	223,634,975.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,712,600.00	15,900,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,145,452.00	2,900,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	39,567,148.00	13,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	165,623.00	1,278,627,511.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	1,213,164,521.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	552,689,309.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	659,475,212.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	165,623.00	65,462,990.11
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	165,623.00	65,462,990.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,543,420.00</u>	<u>5,346,272.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,543,420.00	5,346,272.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,543,420.00	5,346,272.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,543,420.00	5,346,272.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,543,420.00	5,346,272.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-1,543,420.00</u>	<u>-5,346,272.00</u>

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	184,955,094.90	81,261,911.31	-138,113,755.89	128,103,250.33
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	184,955,094.90	81,261,911.31	-138,113,755.89	128,103,250.33
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	69,086,615.66	69,086,615.66
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	193,915,094.90	32,708,084.09	-90,890,305.47	70,316,705.34
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	193,915,094.90	32,708,084.09	-90,890,305.47	70,316,705.34
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-1,776,000.00	-1,776,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	193,915,094.90	32,708,084.09	-92,666,305.47	68,540,705.34
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	45,697,370.76	45,697,370.76
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	193,915,094.90	32,708,084.09	-46,968,934.71	114,238,076.10

4.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,562,009,800.00	1,500,693,946.00	-61,315,854.00	96.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,562,009,800.00	1,500,693,946.00	-61,315,854.00	96.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	297,189,300.00	287,529,425.00	-9,659,875.00	96.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,695,400.00	215,904,066.00	-2,791,334.00	98.7
210101	Үндсэн цалин	148,471,900.00	164,055,835.00	15,583,935.00	110.5
210102	Нэмэгдэл	58,591,700.00	31,835,091.00	-26,756,609.00	54.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,920,000.00	10,704,600.00	2,784,600.00	135.2
210104	Урамшуулал	3,711,800.00	9,308,540.00	5,596,740.00	250.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,294,000.00	26,425,459.00	-6,868,541.00	79.4
210201	Тэтгэврийн даатгал	20,602,000.00	18,209,427.00	-2,392,573.00	88.4
210202	Тэтгэмжийн даатгал	6,998,000.00	2,142,287.00	-4,855,713.00	30.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,518,400.00	1,713,829.00	195,429.00	112.9
210204	Ажилгүйдлийн даатгал	379,600.00	387,555.00	7,955.00	102.1
210205	Эрүүл мэндийн даатгал	3,796,000.00	3,972,361.00	176,361.00	104.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,518,800.00	14,518,800.00	00.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	1,633,100.00	1,487,634.00	-145,466.00	91.1
210302	Түлш, халаалт	11,648,000.00	12,035,688.00	387,688.00	103.3
210303	Цэвэр, бохир ус	1,237,700.00	995,478.00	-242,222.00	80.4
2104	Хангамж, бараа материалын зардал	7,046,000.00	7,046,000.00	00.00	100.0
210401	Бичиг хэрэг	1,450,000.00	717,360.00	-732,640.00	49.5
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	2,801,261.00	-198,739.00	93.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	840,000.00	361,807.00	-478,193.00	43.1
210404	Ном, хэвлэл	300,000.00	27,650.00	-272,350.00	9.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	295,800.00	-204,200.00	59.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	956,000.00	2,842,122.00	1,886,122.00	297.3

Дорноговь аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2019 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,400,000.00	4,400,000.00	00.00	100.0
210604	Урсгал засвар	4,400,000.00	4,400,000.00	00.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	4,000,000.00	4,000,000.00	00.00	100.0
210702	Дотоод албан томилолт	4,000,000.00	4,000,000.00	00.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,735,100.00	1,735,100.00	00.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,735,100.00	1,735,100.00	00.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13500000.00	13500000.00	00.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	500,000.00	00.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,000,000.00	13,000,000.00	00.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1264820500.00	1213164521.00	-51,655,979.00	95.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,264,820,500.00	1,213,164,521.00	-51,655,979.00	95.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	590,475,700.00	552,689,309.00	-37,786,391.00	93.6
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	673,344,800.00	659,475,212.00	-13,869,588.00	97.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	00.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,562,009,800.00	1,500,693,946.00	-61,315,854.00	96.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,562,009,800.00	1,500,693,946.00	-61,315,854.00	96.1
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,562,009,800.00	1,500,693,946.00	-61,315,854.00	96.1
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	18.00	17.00		94.4
620001	Удирдах ажилтан	01.00	01.00		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00		100.0
620003	Үйлчлэх ажилтан	06.00	05.00		83.3

4.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	229,026,775.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	229,026,775.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	229,026,775.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,547,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,547,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	225,079,775.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	225,079,775.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,400,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,400,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	218,948,675.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	218,948,675.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,697,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	175,250,875.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	